



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

“Алтанбулаг” чөлөөт бүсийн үйл ажиллагааны
стратеги, зохион байгуулалтын бүтцийн
өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Чөлөөт бүсийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1.9, Засгийн газрын 2015 оны 126 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Алтанбулаг” чөлөөт бүсийн Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн мөрдүүлж ажиллахыг “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагч /захирагчийн үүргийг түр орло/ гүйцэтгэгч Г.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын Чөлөөт бүсийн хөгжил, аж үйлдвэрийн паркийн хэлтсийн /Т.Чимэгсанаа/-д даалгасугай.





"АЛТАНБУЛАГ" ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Алтанбулаг чөлөөт бус (цаашид "чөлөөт бус" гэх)-ийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэх)-т чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн териин захиргааны төв байгууллага Аж үйлдвэрийн яам (цаашид "яам" гэх), Чөлөөт бүсийн захирагч (цаашид "Захирагч" гэх)- аас шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, чөлөөт бүсийн дэд бүтэц, газрын харилцааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, чөлөөт бүсийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийн технологи, мэдээллийн сангт хөгжүүлэх, санхүү бүртгэлийн асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратеги болон бүтцийн загвар, нэгжүүдийн үндсэн чиг үүргийг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого," болон Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолоор батлагдсан "Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийн ерөнхий загварыг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Чөлөөт бүсийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Улсын бүртгэлийн тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Хот байгуулалтын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Газрын тухай хууль;

- Бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичиг;

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын туршлага, гадаад орчны өөрчлөлт, төрийн захиргааны шинэчлэлийн удирдлага, үйл ажиллагааны онцлог, төлөвлөлт, дахин инженерчлэлийн арга зүй, зохицуулалтын арга зүйг ашиглаж, яам, агентлагийн үйл ажиллагааны стратеги боловсруулж ирсэн туршлага, сургамжийг харгалзсан болно.

1.5. Чөлөөт бүсийн үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Чөлөөт бүс нь эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулах, чөлөөт бүсийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах үүрэг, хариуцлага хүлээж, Аж үйлдвэрийн сайдад мэргэжил, арга зүйн бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч, хэрэгцээний эх үүсвэр

Чөлөөт бүсийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой, бүрэн тодорхойлох нь тус чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратегийг тогтооход чухал ач холбогдолтойг анхаарч хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

**“Алтанбулаг” чөлөөт бүсийн стратегийн удирдлага,
зохицуулалтын үндсэн хэрэглэгч ба хэрэгцээний эх үүсвэр**



Чөлөөт бүсийн үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Аж үйлдвэрийн сайд, Аж үйлдвэрийн яам болно.

Чөлөөт бүсийн стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх бүх төрлийн харилцааг зохицуулахад чиглэнэ.

Чөлөөт бүсийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон ажлын албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллааны стратеги,

албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. "Алтанбулаг" чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аж үйлдвэрийн сайдын эрхлэх ажлын хүрээний чөлөөт бүсийг хөгжүүлэх бодлогын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд үйл ажиллагаанд цаг тухайд нь, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

2.2.1. чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар эдийн засгийн бүтцийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх;

2.2.2. чөлөөт бүсэд тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, дэд бүтцийг хөгжүүлэх;

2.2.3. чөлөөт бүсийн газар зохион байгуулалт, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах;

2.2.4. бүсийн үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлж, орлого, бүтээмжийг ёсгэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх;

2.2.5. чөлөөт бүсийг хөгжүүлэх асуудлаар гадаад орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Олон улсын жишигт хүрсэн чөлөөт бүсийг байгуулж, хөгжүүлснээр бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Чөлөөт бүс нь эрхэм зорилго, тэргүүлэх чиглэлийн хүрээнд дор дурдсан стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.4.1. чөлөөт бүсийн стратегийн зорилтыг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, бодлого боловсруулах, удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;

2.4.2. чөлөөт бүсэд дэд бүтцийг хөгжүүлэх, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, чөлөөт бүсэд газар ашиглуулах, зээмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохион байгуулах;

2.4.3. төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.4.4. гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх, мэдээллийн технологийн найдвартай байдлыг хангах;

2.4.5. чөлөөт бүсийн бүртгэл санхүү, төсвийн удирдлагыг хангах;

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. чөлөөт бүсийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангах бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.5.1.2. аж ахуйн нэгж, байгууллагын боловсруулсан төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалтын үр ашиг, эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт хийх;

2.5.1.3. дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын зөвлөлтэй хамтран ажиллах;

2.5.1.4. салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх;

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. чөлөөт бүсийн төлөвлөлтийн хүрээнд газар эзэмшиүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулах, дэд бүтцийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах;

2.5.2.2. чөлөөт бүсийн дэд бүтцийн хүчин чадалд суурилагдсан бүтээн байгуулалтын ажилд шаардагдах техникийн нөхцөл болон архитектор төлөвлөлтийн даалгавар, төслийн санал боловсруулж баттуулах;

2.5.2.3. чөлөөт бүсийг орчин үеийн өндөр технологийт дэд бүтцийн эх үүсвэрийн нэгдсэн дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын байгууламжийг цогцоор нь шийдвэрлэх;

2.5.2.4. үйлдвэрлэл, үйлчилгээний ил тод байдал, тэдгээрийн зарчим, стандартууд болон байгаль орчинд халгүй дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх;

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр дүнг нэгтгэн дүгнэх, тайлагнах;

2.5.3.2. хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх явцад эрх зүйн зөвлөгөө өгөх, хууль

тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах талаар хяналт-шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөмж гаргах;

2.5.3.3. иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх;

2.5.3.4. дээд байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийн мэдээ, тайланг гаргах;

2.5.4.Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг сурталчлах, холбогдох санал гаргах, дэмжлэг үзүүлэх;

2.5.4.2. салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн технологи, мэдээллийн сүлжээ, санг хөгжүүлэх, найдвартай ажиллагааг хангах;

2.5.4.3. хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд болон олон улсын хөрөнгө оруулалтын гэрээ хэлцэлийн үндэслэлийг боловсруулах, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, хэрэгжилтийг хангах;

2.5.4.4. салбарын мэргэжилтэн боловсон хүчинийг бэлтгэх, сургах, давтан бэлтгэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах;

2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1. чөлөөт бүсийн санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн зохион байгуулах, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах;

2.5.5.2. гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлтэй холбоотой хураамж төлбөр тооцоог зохих журмын дагуу бүрдүүлэх, тайлагнах;

2.5.5.3. төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, тоног төхөөрөмж, худалдан авах үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаанаа ил тод байдлыг хангаж ажиллах;

2.5.5.4. чөлөөт бүсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг гүйцэтгэх, хяналтыг үнэн зөв гүйцэтгэх;


2.6. Үйл ажиллагааны зорилт

Чөлөөт бүсийн үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, ажилтнуудын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусган ажиллана.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Чөлөөт бүсийн үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

"АЛТАНБУЛАГ" ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
(БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



Гурав. "Алтанбулаг" чөлөөт бүсийн бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1. "Алтанбулаг" чөлөөт бүсийн бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад баримтлах зарчим:

3.1.1. чөлөөт бүсийн стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (тухайн чөлөөт бүсийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2. эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3.1.3. үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын дүр төрх харагдахуйц байх, тухайлбал чөлөөт бүсийн бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4. бүтцийн хувьд энгийн байх зарчим (ажлын албаны даргаас хамгийн доод нэгжийг хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5. тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоо зарчим (чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчиний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);


3.1.6. улс төржихгүй байх зарчим (тухайн чөлөөт бүсийн албан хаагч нь захирагч, ажлын албаны дарга болон бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төржихгүй байж, өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн аливаа нөлөөлелд автахгүй байх);

3.1.7. хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх);

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон "Алтанбулаг" чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус албаны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны дараахъ загвар гарч байна:

"Алтанбулаг" чөлөөт бүсийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн чиг үүргийг тодорхойлов:

3.3.1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд чөлөөт бүсийн салбарын хууль тогтоомж, урт дунд хугацааны хөгжлийн цогц бодлого, стратеги төлөвлөлт, хөрөнгө оруулалтын төсөл, хетөлбөрүүд боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, холбогдох судалгаа гүйцэтгэх үндсэн үүрэг хүлээнэ. Энэ үндсэн чиг үүргийн хүрээнд чөлөөт бүсийн эдийн засаг, хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, шинээр байгуулах гэрээ, хэлэлцээрийн талаар санал боловсруулах, хэрэгжилтийн явцад үнэлгээ өгөх, Захирагчийн төсвийн багцыг төлөвлөх, эрхлэх, тайлагнах үйл ажиллагааг зохицуулах, үйлчилгээ үзүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь чөлөөт бүсийн салбарын шинэчлэлийн бодлогыг эдийн засаг, эрх зүйн болон тогтолцооны хувьд үндэслэл бүхий хууль тогтоомж, бодлогын хувилбар, оновчтой шийдэл бүхий шийдвэрийн төсөл, бодлого, эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах, эдийн засгийн орчин, хөрөнгө оруулалтын нөхцөл, бололцоог судлах замаар энэ салбарын бодлогыг үндэсний аюулгүй байдал, иргэдийн хүсэн хүлээж байгаа хүсэл сонирхолд нийцүүлэхэд чиглэгдэнэ. Үүний тулд энэ нэгжийн удирдлага, ажилтнууд нь багаар ажиллаж ажлын байран дээр суралцахын зэрэгцээ бусад яамны зохион байгуулалтын ижил төрлийн бүтцийн нэгжийн удирдлага, ажилтнуутдай ажил төрөл, мэдлэг, ур чадвараа өсгөх чиглэлээр хамтран ажиллаж, аливаа асуудлыг зөвхөн салбарын төдийгүй, улсын хэмжээнд тогтолцооны онолд тулгуурлан асуудалд хандаж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Захирагч, Захирагчийн ажлын албаны дарга, Засгийн газрын зүгээс Аж үйлдвэрийн яамны сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар болон холбогдох аж ахуйн нэгж, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тунш нь ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аймаг, сумын Засаг дарга байна.

3.3.2. Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн хоёрдуугаар зорилтын хүрээнд чөлөөт бүсийн дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны асуудлыг зохион байгуулах үндсэн үүрэг хүлээж, чөлөөт бүсийн үйл ажиллагааг хэвийн явуулахад дулаан хангамж, усан хангамж, цахилгаан хангамж, авто зам холбоо, газар олголт, газрын харилцааг оновчтой зохион байгуулж хэрэглэгчдэд найдвартай үйл ажиллагааг хүргэх, гэрээт аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжилтийг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгж нь Захирагч, Захирагчийн ажлын албаны дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийг дүгнэлт, зөвлөмж, мэдээллээр хангаж шийдвэр гаргах механизмыг дэмжлэг үзүүлэх, Захирагчийг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Захирагч, Захирагчийн ажлын албаны дарга, төрийн зүгээс Аж үйлдвэрийн яам байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар болон холбогдох аж ахуйн нэгж, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тунш нь Барилга хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Зам тээврийн яам болон холбогдох бусад яам, агентлаг, аж ахуйн нэгжүүд байна.

3.3.3. Гэрээ, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, чөлөөт бүсийн болон холбогдох бусад хууль тогтоомжуудад нийцүүлэн эрх зүйн акт, гэрээ журам, төсөл хөтөлбөрийг хянах үндсэн үүрэг хүлээж, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гарган гүйцэтгэлийг хангуулах, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь чөлөөт бүсийн үйл ажиллагааны төлөвлөлт, түүнийг зохион байгуулах ажлыг хариуцан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хууль тогтоомжийн хэрэгжилт болон албан хэрэг хөтлөх, үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах, аливаа шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж баталгаажуулах замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, захирагч, ажлын албаны дарга, бүтцийн нэгжүүдийн дарга, ажилтнуудад арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ. Энэ нэгж цомхон чадварлаг албан хаагч бүхий мэргэшсэн албаны хүчээр чөлөөт бүсийн тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангах, тэднийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг бүрдүүлэх, чадавхийг сайжруулах, тэдний ажлын үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлж, дүгнэх ажлыг зохион байгуулж, зохицуулах үүрэгтэй.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Захирагч, Захирагчийн ажлын албаны дарга, төрийн зүгээс Аж үйлдвэрийн яам байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг болон холбогдох аж ахуйн нэгж, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвшний Хууль зүйн яам болон бусад яам, агентлаг, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

3.3.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологи хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон нийттэй харилцах, мэдээлэл технологийн найдвартай ажиллагааг хангах үндсэн үүрэг хүлээж, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, зах зээлийн таатай нөхцлийн талаар хөрөнгө оруулагчдад сурталчлах, хөрөнгө оруулалтын үр ашиг, эрсдэлийн шинжилгээ, төсөл боловсруултахтай холбоотой судалгаа, шинжилгээ хийх, олон улсын гэрээ хэлцэл, хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн төсөл, үндэслэлийг боловсруулах, чөлөөт бүсийн мэдээллийн технологи, мэдээллийн сүлжээ, санг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Захирагч, Захирагчийн ажлын албаны дарга, төрийн зүгээс Аж үйлдвэрийн яам байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар болон гадны хөрөнгө оруулагчид, хамтын ажиллагаатай байгууллага, холбогдох аж ахуйн нэгж, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвшний Гадаад харилцааны яам болон холбогдох бусад яам, агентлаг, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд байна.

**3.3.5. Бүртгэл, санхүүгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж
/Аж ахуйн үйлчилгээ, ашиглалтын тасаг/, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн тавдугаар зорилтын хүрээнд чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, компаниудыг бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт, санхүүгийн менежментийг боловсронгуй болгох, аж ахуйн үйлчилгээ, ашиглалтын тасаг нь бусийн төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, сантехник, цахилгаан болон бусад засвар үйлчилгээг зохион байгуулах ажлыг хариуцах, бүсэд хийгдсэн дэд бүтцийн ажлуудыг улсын комисс хүлээн авсны дараахи ашиглалтын үйл ажиллагааг хариуцах, тухайн барилга байгууламжуудыг холбогдох мэргэжлийн байгууллагад шилжүүлэх, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, Захирагчийн ажлын албаны конторын эд хөрөнгийн ашиглалтанд хяналт тавих, албан хэрэгцээний эд зүйлсийн хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Захирагч, Захирагчийн ажлын албаны дарга, төрийн зүгээс Аж үйлдвэрийн яам байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар болон гадны хөрөнгө оруулагчид, хамтын ажиллагаатай байгууллага, холбогдох аж ахуйн нэгж, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тунш нь Сангийн яам болон холбогдох бусад яам, агентлаг, аж ахуйн нэгжүүд байна.

----ooOoo----